



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар
толь бичиг хувилбар 1.0 батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14 дэх заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт ашиглагдах програм хангамжийн мэдээний өгөгдлийн санг зохион байгуулахад мөрдөх эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг хувилбар 1.0-ийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах програм хангамжийн мэдээний өгөгдлийн санг зохион байгуулахад эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг хувилбар 1.0-ийг мөрдөж ажиллахыг бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяад/-д даалгасугай.

САЙД




Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

081795

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 09 сарын 05 өдрийн
295 дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨГӨГДЛИЙН ТАЙЛБАР ТОЛЬ БИЧИГ

ХУВИЛБАР 1.0

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын нэр	1
Эрүүл мэндийн байгууллагын код	2

2. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог.....	3
Эцэг/эхийн нэр.....	4
Өөрийн нэр	5
Иргэний харьяалал.....	6
Регистрийн дугаар.....	7
Төрсөн он сар өдөр.....	8
Нас/насанд хүрэгсэд.....	9
Нас/хүүхэд	10
Хүйс.....	11
Боловсрол.....	12-13
Албан байгууллага/ажил олгогч	14-15
Ажил/мэргэжил.....	16-17
Байнга оршин суугаа хаяг/аймаг, хот.....	18-19
Байнга оршин суугаа хаяг/сум, дүүрэг.....	20-21
Байнга оршин суугаа хаяг/баг, хороо.....	22-23
Байнга оршин суугаа хаяг/гудамж, байшин.....	24-25
Үйлчлүүлэгчийн холбоо барих утас.....	26
Яаралтай үед холбоо барих хүний нэр, утас.....	27

3. АМБУЛАТОРЫН ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

Амбулаторын кабинетийн нэр.....	28
Үзлэгийн эмчийн нэр.....	29
Эмчийн үзлэгийн цагийн товллол авсан он сар өдөр, цаг, минут.....	30
Оношилгооны кабинетаар үйлчлүүлэх цагийн товллол авсан он сар өдөр, цаг, минут.....	31
Лабораторын шинжилгээний цаг товллол авсан он сар өдөр, цаг, минут.....	32
Эмчийн үзлэгийн төлбөр.....	33
Оношилгооны төлбөр.....	34
Лабораторын шинжилгээний төлбөр.....	35
Үзлэг эхэлсэн цаг минут.....	36
Үзлэгийн төрөл.....	37-38
Өвчний төрөл.....	39
Үндсэн онош.....	40
Осол гэмтлийн шалтгаан.....	41
Авсан арга хэмжээ.....	42

4. ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ

Эмийн нэр	43
Эмийн тун/хэмжээ.....	44-46
Эмийн хэлбэр.....	47-49
Эмийн үнэ.....	50



5. ЭМНЭЛГЭЭС ГАРАХ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Үндсэн онош.....51
Хавсарсан/дагалдах онош.....52
Хүндрэлийн онош.....53
Үйлдлийн онош.....54
Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр.....55
Эмнэлгээс гарсан он сар өдөр.....56
Нас барсан он сар өдөр.....57
Эмнэлгээс гарсан байдал.....58
Ор хоног.....59
Эмчилгээний нийт зардал60
Хэвтүүлэн эмчлэх тасгийн нэр.....61
Эмчлэгч эмчийн нэр.....62

6. ДААТГАЛЫН ТӨЛБӨР ТООЦООТОЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ


Даатгалын байгууллагын нэр63-64
Даатгуулагчийн эрүүл даатгалын дэвтрийн дугаар.....65
Даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтрийн дугаар.....66
Өртөг ойролцоо оношийн бүлгийн дугаар.....67-68
Өртөгийн жин69
Даатгуулагчийн өөрөө хариуцах төлбөр.....70-71
Даатгуулсан байдал.....72
Даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний төрөл.....73-74
Даатгалын төрөл.....75-76
Даатгуулагчийн төрөл77-78
Даатгалын байгууллага/сангаас нэхэмжлэх нийт зардал.....79-80
Даатгалын байгууллага/сангаас олгосон нийт зардал.....80-82

Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг

хувилбар 1.0

I.ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын хууль ёсны байгууллагууд бүртгүүлсэн нэрийг хэлнэ.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Техт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	100
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Эрүүл мэндийн байгууллагын нэр
Заавар	Эрүүл мэндийн байгууллагын нэрийг товчлохгүй, дармалаар бүрэн гүйцэд бичнэ.
Холбоос	-
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	Байгууллагын аж ахуй нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл тусгай зөвшөөрөл
Байгууллага	-Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	



5

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН КОД	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг тусламж үйлчилгээний шатлалаар ангилсан код
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	##/##/##
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	6
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	6
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг тусламж үйлчилгээний шатлалаар ангилсан 6 оронтой код байна.
Заавар	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг тусламж үйлчилгээний шатлалаар ангилсан 6 оронтой тооны эхний 2 орон нь тухайн эрүүл мэндийн байгууллагын харьяалагдах засаг захиргааны нэгжийн аймаг, хотын код, дараагийн 2 орон сум, дүүргийн код, харин хамгийн сүүлийн орон тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний шатлалын код байна.
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	Эрүүл мэндийн байгууллагын ангилал
Байгууллага	Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаал
Нэмэлт тайлбар	



II. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

УРГИЙН ОВОГ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн ургийн овгийн оноосон нэрийг хэлнэ.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	30
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Ургийн овгийн оноосон нэр
Заавар	Ургийн овгийг товчлохгүй, дармалаар бүрэн гүйцэд бичнэ.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	<ul style="list-style-type: none"> - Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 1.7 дүгээр хэсэг "Ургийн овог гэж өвөг дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг" хэлнэ.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 17 дугаар тогтоолын хавсралт "Угийн бичиг хөтлөх журам"-д зааснаар:</p> <p>Овгийг эцгийн шугам буюу ясан төрлийг баримтлан үе уламжлан хэрэглэнэ. Өвөг дээдсээсээ уламжлан ирсэн эцгийн овгийг мэддэг хүмүүс түүнийгээ шууд хэрэглэнэ.</p> <p>Монгол Улсын "Иргэний бүртгэлийн тухай" хуулийн 12 дугаар зүйл /1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр/ 12.11. Төрсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 12.11.1. хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, газар; 12.11.2. эцэг, эхийн овог, эцэг, эхийн эцгийн(эхийн) нэр, эцэг, эхийн нэр;</p>

ЭЦЭГ/ЭХИЙН/ НЭР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн нэр.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Техт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	30
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Эцэг/эх/-ийн нэр
Заавар	Эцэг/эх/-ийн нэрийг товчлохгүй, дармалаар бүрэн гүйцэд бичнэ.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	<ul style="list-style-type: none"> - Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 24 дүгээр зүйл. “Хүүхдийн нэр, эцгийн нэр, овог”</p> <p>24.3 Хүүхэд эцгийн нэрийг авна.</p> <p>24.4 Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн, эсвэл хүүхдийн эцгийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэргүй бол хүүхэд эхийн нэрийг авна.</p> <p>24.5 Үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн нэрийг авч болно</p> <p>Монгол Улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн 12 дугаар зүйл /1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр/</p> <p>12.11. Төрсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:</p> <p>12.11.1. хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, газар;</p> <p>12.11.2. эцэг, эхийн овог, эцэг, эхийн эцгийн(эхийн) нэр, эцэг, эхийн нэр;</p>

ӨӨРИЙН НЭР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Иргэний бүртгэлд хууль ёсоор бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн нэр байна.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Техт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	30
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн нэр
Заавар	Үйлчлүүлэгчийн нэрийг товчлохгүй, дармалаар бүрэн гүйцэд бичнэ.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	<ul style="list-style-type: none"> - Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын "Иргэний хууль"-ийн 20 дугаар зүйл /2000 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр/</p> <p style="padding-left: 40px;">20.1.Иргэн өөрийн нэртэй байна.</p> <p style="padding-left: 40px;">20.2.Иргэний нэрийг бүртгэх, өөрчлөх журмыг хуулиар тогтооно.</p> <p>Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалт / 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр/</p> <p style="padding-left: 40px;">"Эцэг, эх тохиролцсоны үндсэн дээр хүүхэддээ нэр, овог өгнө"</p> <p style="padding-left: 40px;">"Олдсон хүүхдэд сум, дүүргийн Засаг дарга, эсхүл иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагын ажилтан нэр, овог өгч болно."</p> <p>12.11. Төрсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:</p> <p style="padding-left: 40px;">12.11.1. хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, газар;</p>

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Монгол улсын иргэний харьяалалтай хүнийг Монгол улсын иргэн, бусад улсын харьяалалтай бол гадаадын харьяат иргэн гэнэ.
Хэрэглээ	-
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	#
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	1
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	1- Монгол улсын иргэн 2- Гадаадын иргэн
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	- Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Харьяатын тухай” хуулийн 5 дугаар зүйл. Иргэний харьяаллыг гэрчлэх баримт бичиг</p> <p>1. Монгол улсын иргэний харьяаллыг гэрчлэх баримт бичиг нь Монгол Улсын иргэний үнэмлэх, түүнийг авах хүртэл хугацаанд төрсний гэрчилгээ байна.</p> <p>2. Монгол улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, харьяалалгүй эцэг эхээс төрсөн хүүхдэд олгосон төрсний гэрчилгээг зөвхөн түүний төрснийг нотлох баримт бичиг гэж үзнэ.</p>

РЕГИСТРИЙН ДУГААР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн Монгол улсын иргэнийг нэгэн утгатай тодорхойлсон үсэг, тооноос бүтсэн нийлмэл код юм.
Хэрэглээ	Мэдээллийн сангаас шүүлт хийхэд гол түлхүүр үг болно.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	ХХ#####
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	10
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	10
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үсэг, тооноос бүтсэн нийлмэл код бүхий үйлчлүүлэгчийн регистрийн дугаар
Заавар	Регистрийн дугаарын эхний 2 орон буюу үсэг нь регистрийн дугаар авч байгаа иргэний байнга оршин суудаг аймаг/дүүрэг, сум/хорооны код, дараагийн 6 орон нь төрсөн он, сар, өдөр, 9 дэх орон нь хүйс, сүүлийн 1 орон нь хяналтын код байна.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	<ul style="list-style-type: none"> - Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн 28 дугаар зүйл</p> <p>28.1. Монгол улсын харьяат иргэн бүр регистрийн дугаартай байна.</p> <p>28.2. Регистрийн дугаар нь Монгол Улсын иргэний үнэмлэх, эсхүл түүнийг орлох баримт бичиг, энгийн гадаад паспорт болон иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ, хадгаламж, даатгалын дэвтэр, жолоодох эрхийн үнэмлэх зэрэг баримт бичигт бичигдэнэ.</p>

ТӨРСӨН ОН САР ӨДӨР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн төрсөн он, сар, өдрийг хэлнэ.
Хэрэглээ	Хүн ам зүйн статистик, дүн шинжилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Огноо
Өгөгдлийн харагдах хэлбэр	0000/CC/ӨӨ
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	8
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	8
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Төрсөн он сар өдөр
Заавар	Он, сар, өдрийг тэмдэглэхдээ эхлээд он дараа нь сар төгсгөлд нь өдөр бичигдэнэ. Товчоор, оныг "о" үсгээр сарыг "с" үсгээр, өдрийг "ө" үсгээр тус тус тэмдэглэвэл 0000/CC/ӨӨ гэсэн хэлбэр буюу дарааллаар тухайн он, сар, өдөр бичигдэнэ.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	– Төрсний гэрчилгээ – Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	Монгол улсын "Иргэний бүртгэлийн тухай" хууль 12.11. Төрсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 12.11.1. хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, газар; 12.11.2. эцэг, эхийн овог, эцэг, эхийн эцгийн(эхийн) нэр, эцэг, эхийн нэр; 12.11.3. төрсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний болон регистрийн дугаар; 12.11.4. төрсний бүртгэл үйлдсэн он, сар, өдөр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг; 12.11.5. төрсний гэрчилгээ олгосон он, сар, өдөр

НАС /Насанд хүрэгчид/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Тооцоолж бодох өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн төрсөн он, сар, өдрөөс тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн он, сар, өдрийн ялгавраар илэрхийлэгдэнэ.
Хэрэглээ	Хүн ам зүйн статистик, дүн шинжилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	###
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	3
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн нас
Заавар	Төрсөн өдрөөс (он, сар, өдөр) эхлэн бүтэн жилүүдээр тооцсон хугацаа, төрсөн сар, жилийн асуултын хариултад суурилсан тооцоогоор илэрхийлсэн хугацаагаар илэрхийлэгдэнэ.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	<ul style="list-style-type: none"> - Төрсний гэрчилгээ - Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	<p>Амьдралын циклээр бүлэглэсэн насыг хүүхэд (0-14), залуу (15-24), насанд хүрэгсэд (25-64), ахмад (65 ба дээш) гэж ангилна.</p> <p>Эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээлэлд ДЭМБ-аас зөвлөмж болгодог А бүлгийн насны ангиллыг ашигладаг. Үүнд:</p> <p>а/ 1 хүртэлх нас, 5 хүртэлх нас (нас тус бүрээр), 5-84 насны хооронд 5 насны бүлгээр, 85 ба түүнээс дээш</p> <p>б/1 хүртэлх нас, 1-4 нас, 5-14 нас, 15-24 нас, 25-34 нас, 35-44 нас, 45-54 нас, 55-64 нас, 65-74 нас, 75 ба түүнээс дээш нас</p> <p>в/1 хүртэлх нас, 1-4 нас, 15-44 нас, 45-65 нас, 65 ба түүнээс дээш нас</p>

НАС /Хүүхэд/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Тооцоолж бодох өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн төрсөн он, сар, өдрөөс тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн он, сар, өдрийн ялгавраар илэрхийлэгдэнэ.
Хэрэглээ	Хүн ам зүйн статистик, дүн шинжилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	## цаг, ##хоног, ## сар,## жил
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн нас
Заавар	Төрсөн өдрөөс (он, сар, өдөр) эхлэн бүтэн жилүүдээр тооцсон хугацаа, төрсөн сар, жилийн асуултын хариултад суурилсан тооцоогоор илэрхийлсэн хугацаагаар илэрхийлэгдэнэ. Нярай хүүхдийн насыг хоногоор, 28 хоногоос 1 хүртэлх насны хүүхдийг сараар, 5-15 хүртэл насны хүүхдийн насыг жилээр тооцно.
Холбоос	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	– Төрсний гэрчилгээ – Иргэний үнэмлэх
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	Амьдралын циклээр бүлэглэсэн насыг хүүхэд (0-14), залуу (15-24), насанд хүрэгсэд (25-64), ахмад (65 ба дээш) гэж ангилна. ДЭМБ-аас зөвлөмж болгодог А бүлгийн насны ангилалыг ашиглахыг дараах ангилалыг эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээлэлд ашигладаг. Үүнд: а/ 1 хүртэлх нас, 5 хүртэлх нас (нас тус бүрээр), 5-84 насны хооронд 5 насны бүлгээр, 85 ба түүнээс дээш б/1 хүртэлх нас, 1-4 нас, 5-14 нас, 15-24 нас, 25-34 нас, 35-44 нас, 45-54 нас, 55-64 нас, 65-74 нас, 75 ба түүнээс дээш нас в/1 хүртэлх нас, 1-4 нас, 15-44 нас, 45-65 нас, 65 ба түүнээс дээш нас

ХҮЙС	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Хүйс гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялангуяа нөхөн үржихүйн эрхтэн, үйл ажиллагааны ялгааг хэлнэ.
Хэрэглээ	Хүн ам зүйн болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг хүйсээр тооцож гаргахад ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/текст
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	1
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	1- Эрэгтэй 2- Эмэгтэй
Заавар	-
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэмэлт тайлбар	Хүйс нь нөхөн үржихүйн эрхтэн, үйл ажиллагаанд тулгуурлан төрөл зүйлийг эмэгтэй, эрэгтэйд ангилах шинж чанар

Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг

хувилбар 1.0



БОЛОВСРОЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Тухайн үйлчлүүлэгчийн эзэмшсэн боловсролын агуулгын дээд түвшин.
Хэрэглээ	Хүн амын өвчлөлийн тандалт, судалгаанд ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/текст
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	1
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	<ol style="list-style-type: none"> 1- Бага боловсрол 2- Бүрэн бус дунд 3- Бүрэн дунд 4- Техникийн болон мэргэжлийн 5- Тусгай мэргэжил 6- Дээд
Заавар	<p>Тухайн хүний боловсролын түвшинг боловсрол эзэмшсэн хамгийн дээд түвшингээр авах бөгөөд Монгол улсад мөрдөгдөж буй боловсролын түвшингийн ангиллын кодоос сонгоно.</p> <p>1-3. Бүрэн дунд хүртэлх боловсрол.</p> <p>Бүрэн дунд хүртэлх боловсролын түвшинг дараах байдлаар тодорхойлох бөгөөд өдөр, орой эчнээгээр төгссөн болон албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагдаж төгссөн хүнийг хамруулна.</p> <p>4. Техникийн болон мэргэжлийн боловсрол.</p> <p>Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг энэ ангилалд хамруулна.</p> <p>5. Тусгай мэргэжлийн дунд боловсрол. Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.</p> <p>6. Дээд боловсрол /диплом, бакалавр, магистр, доктор</p>

	<p>ба түүнээс дээш/.</p> <p>Гадаад, дотоодын их дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой үзнэ.</p>
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	(ҮСХ-ны боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлагын ангилал)
Байгууллага	Үндэсний статистикийн хороо
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Боловсролын тухай” хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар: /2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр/ Гэрчилгээ, үнэмлэх, диплом зэрэг боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшин, мэргэжлийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.</p> <p>Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар: /2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр/</p> <p>-“Боловсролын агуулга” гэж боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төлөвшлийн цогцыг хэлнэ. Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.</p> <p>-“Боловсролын түвшин” гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг хэлнэ.</p>

АЛБАН БАЙГУУЛЛАГА/АЖИЛ ОЛГОГЧ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Тухайн хүний ажиллаж буй байгууллагын нэр байх бөгөөд уг ажил нь үйл ажиллагааны үндсэн чиглэлийн аль ангилалд багтаж байгаагаар тодорхойлогдоно.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	<p>Монгол улсад мөрдөгдөж буй “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”ын жагсаалт</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 2. Уул уурхай, олборлолт 3. Боловсруулах үйлдвэр 4. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж 5. Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 6. Барилга 7. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ 8. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 9. Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа 10. Мэдээлэл, холбоо 11. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 12. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 13. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 14. Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 15. Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 16. Боловсрол 17. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 18. Урлаг, үзвэр, тоглоом, наадам 19. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 20. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа 21. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн

	үйл ажилагаа
Заавар	<p>Тухайн хүний ажиллаж буй байгууллага, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн аль ангилалд багтаж байгаа ажил олгогч байгууллагын кодоос сонгоно.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар "ажил олгогч" гэж хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг хэлнэ.</p> <p>Олон улсын ижил төстэй мэдээлэлтэй зэрэгцүүлэх үүднээс НҮБ "Бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангилал (ISIC)-ыг мөрдөхийг зөвлөмж болгодог.</p> <p>Монгол улс нь 2011 онд сангийн сайдын тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг мөрдөж байна. Энэ ангилал нь ААНБ-уудын эрхэлдэг үйл ажиллагааг салбараар ангилсан ангилал юм.</p>
Холбоос	-
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	Монгол улсад мөрдөгдөж буй "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ын жагсаалт, 2011 онд Сангийн сайдын тушаал
Байгууллага	Сангийн яам, Үндэсний статитикийн хороо
Нэмэлт тайлбар	


МЭРГЭЖИЛ/АЖИЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Тухайн эзэмшсэн мэргэжил бөгөөд Монгол улсад мөрдөж байгаа "YAMAT-08" ангиллын аль ангилалд багтаж байгаагаар тодорхойлогдоно.
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	4
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	<p>Монгол улсад мөрдөгдөж буй "YAMAT-08" ангилал нь 10 үндсэн бүлэг-1 кодтой</p> <ol style="list-style-type: none"> 1. Менежер 2. Мэргэжилтэн 3. Техникч болон туслах/дэд мэргэжилтэн 4. Контор, үйлчилгээний ажилтан 5. Худалдаа үйлчилгээний ажилтан 6. Хөдөө аж, ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 7. Үйлдвэрлэл, барилга, гар урлалд холбогдох ажил үйлчилгээний ажилтан 8. Машин механизм, тоног төхөөрөмжийн техникч, угсрах ажилтан 9. Энгийн ажил мэргэжил 10. Бусад
Заавар	<p>Монгол улсад мөрдөгдөж буй "YAMAT-08" ангилал нь 10 үндсэн бүлэг-1 кодтой 43 дэд бүлэг -2 кодтой 153 бага бүлэг-3 кодтой 421 нэгж бүлэг-4 кодтой 3978 мэргэжлийн бүлэг-7 кодтой</p> <p>Монгол улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 ("YAMAT-08") -ын 1 ба 2, 3 дугаар үндсэн бүлэгт их, дээд сургуулийн болон түүний дараах шатны боловсролын, түүнтэй адилтгах түвшин шаардагдах ажил мэргэжлийг, 4-8 дугаар үндсэн бүлэгт мэргэжлийн дунд шатны боловсрол шаардах ажил,</p>

Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг

хувилбар 1.0

21

	<p>мэргэжлийг, 9 дүгээр үндсэн бүлэгт бага, бүрэн бус дунд боловсролтой буюу мэргэжлийн анхан шатны боловсрол үл шаардах энгийн ажлыг, 0 дугаар үндсэн бүлэгт зэвсэгт хүчний зэрэглэлийн ажил, мэргэжлийг тус тус ангилсан болно.</p>
Холбоос	-
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт-08 /Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2-р сарын 10-ны өдрийн 16 тушаал/
Байгууллага	Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам
Нэмэлт тайлбар	



БАЙНГА ОРШИН СУУГАА ГАЗАР /АЙМАГ, ХОТ/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн аймаг/хот/-ын нэр байна.
Хэрэглээ	Хүн ам зүйн болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг газарзүйн байршлаар тооцож гаргахад ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	2
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Аймаг, хотын нэр
Заавар	<p>Тухайн үйлчлүүлэгчийн хуулийн дагуу бүртгүүлэгдсэн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хорооны нэр, дугаарыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн аймаг, хотын кодын жагсаалтаас сонгоно.</p> <p>Байнгын оршин суугч. Энэ ангилалд тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүмүүс болон цаашид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүмүүсийг хамруулна.</p> <p>Түр оршин суугч. Энэ ангилалд өөр засаг захиргааны нэгжээс ирсэн, тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар оршин сууж буй хүмүүсийг хамруулна.</p> <p>Хаягийн бүртгэлгүй оршин суугч. Тухайн засаг, захиргааны нэгж (баг,хороо)-д албан ёсоор бүртгүүлээгүй, хаягийн бүртгэлгүйгээр 180-аас дээш хоногоор оршин сууж буй хүнийг хаягийн бүртгэлгүй оршин суугч гэнэ.</p>
Холбоос	-УБЕГ-ын хүн амын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-ҮСХ, УБЕГ, МШХХТГ-ын даргын 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 01/62, 226, 58 тоот хамтарсан тушаалын хавсралт

	<p>-“Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, нэгтгэлийн маягтыг нөхөх заавар” Үндэсний Статистикийн Хороо</p>
Байгууллага	Үндэсний статистикийн хороо
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль-д</p> <p>3 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж</p> <p>3.1.Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> <p>3.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p> <p>Монгол улсын “Иргэний хууль”-д:</p> <p>22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар</p> <p>22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.</p> <p>22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно.</p> <p>22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.</p>

БАЙНГА ОРШИН СУУГАА ГАЗАР /СУМ, ДҮҮРЭГ/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн хамгийн сүүлийн хуулийн 1 дагуу харьяалагдан бүртгүүлсэн сум/дүүрэг/-ын нэр байна.
Хэрэглээ	Хүн ам зүйн болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг газарзүйн байршлаар тооцож гаргахад ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	2
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Сум,дүүргийн нэр
Заавар	<p>Тухайн үйлчлүүлэгчийн хуулийн дагуу бүртгүүлэгдсэн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хорооны нэр, дугаарыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн аймаг, хотын кодын жагсаалтаас сонгоно.</p> <p>Байнгын оршин суугч. Энэ ангилалд тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүмүүс болон цаашид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүмүүсийг хамруулна.</p> <p>Түр оршин суугч. Энэ ангилалд өөр засаг захиргааны нэгжээс ирсэн, тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар оршин сууж буй хүмүүсийг хамруулна.</p> <p>Хаягийн бүртгэлгүй оршин суугч. Тухайн засаг, захиргааны нэгж (баг,хороо)-д албан ёсоор бүртгүүлээгүй, хаягийн бүртгэлгүйгээр 180-аас дээш хоногоор оршин сууж буй хүнийг хаягийн бүртгэлгүй оршин суугч гэнэ.</p>
Холбоос	- УБЕГ-ын хүн амын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	

Үндсэн баримт	<p>-ҮСХ, УБЕГ, МШХХТГ-ын даргын 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 01/62, 226, 58 тоот хамтарсан тушаалын хавсралт</p> <p>-“Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, нэгтгэлийн маягтыг нөхөх заавар” Үндэсний Статистикийн Хороо</p>
Байгууллага	Үндэсний статитикийн хороо
Нэмэлт тайлбар	<p>Монгол улсын “Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль-д 3 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж</p> <p>3.1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> <p>3.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p> <p>Монгол Улсын “Иргэний хууль”-д:</p> <p>22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар</p> <p>22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.</p> <p>22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно.</p> <p>22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.</p>


БАЙНГА ОРШИН СУУГАА ГАЗАР /БАГ, ХОРОО/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн баг/хороо/-ийн нэр, дугаар байна.
Хэрэглээ	Хүн ам зүйн болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг газарзүйн байршлаар тооцож гаргахад ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	2
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Баг/хорооны нэр, дугаар
Заавар	<p>Тухайн үйлчлүүлэгчийн хуулийн дагуу бүртгүүлэгдсэн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хорооны нэр, дугаарыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн аймаг, хотын кодын жагсаалтаас сонгоно.</p> <p>Байнгын оршин суугч. Энэ ангилалд тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүмүүс болон цаашид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүмүүсийг хамруулна.</p> <p>Түр оршин суугч. Энэ ангилалд өөр засаг захиргааны нэгжээс ирсэн, тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар оршин сууж буй хүмүүсийг хамруулна.</p> <p>Хаягийн бүртгэлгүй оршин суугч. Тухайн засаг, захиргааны нэгж (баг,хороо)-д албан ёсоор бүртгүүлээгүй, хаягийн бүртгэлгүйгээр 180-аас дээш хоногоор оршин сууж буй хүнийг хаягийн бүртгэлгүй оршин суугч гэнэ.</p>
Холбоос	- УБЕГ-ын хүн амын мэдээний сан
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	- ҮСХ, УБЕГ, МШХХТГ-ын даргын 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 01/62, 226, 58 тоот хамтарсан тушаалын хавсралт

	<p>-“Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, нэгтгэлийн маягтыг нөхөх заавар” Үндэсний Статистикийн Хороо</p>
<p>Байгууллага</p>	<p>Үндэсний статистикийн хороо</p>
<p>Нэмэлт тайлбар</p>	<p>Монгол улсын “Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль-д 3 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж</p> <p>3.1.Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> <p>3.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p> <p>Монгол Улсын “Иргэний хууль”-д: 22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар 22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.</p>

БАЙНГА ОРШИН СУУГАА ГАЗАР /ГУДАМЖ/ХОРООЛЛЫН НЭР, БАЙР, ХАШААНЫ ДУГААР/	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн гудамж, байрны нэр, дугаар байна.
Хэрэглээ	Хүн ам зүйн болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг газарзүйн байршлаар тооцож гаргахад ашиглана.
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	-
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	-
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Гудамж/хороолол, хашаа/байрны нэр, дугаар
Заавар	<p>Тухайн үйлчлүүлэгчийн хуулийн дагуу бүртгүүлэгдсэн хамгийн сүүлийн хуулийн дагуу харьяалагдан бүртгүүлсэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хорооны нэр, дугаарыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн аймаг, хотын кодын жагсаалтаас сонгож, харин гудамж, байрны нэр, байр, хашааны дугаарыг шивж оруулна.</p> <p>Байнгын оршин суугч. Энэ ангилалд тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүмүүс болон цаашид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүмүүсийг хамруулна.</p> <p>Түр оршин суугч. Энэ ангилалд өөр засаг захиргааны нэгжээс ирсэн, тухайн засаг захиргааны нэгж (баг,хороо)-д 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар оршин сууж буй хүмүүсийг хамруулна.</p> <p>Хаягийн бүртгэлгүй оршин суугч. Тухайн засаг, захиргааны нэгж (баг,хороо)-д албан ёсоор бүртгүүлээгүй, хаягийн бүртгэлгүйгээр 180-аас дээш хоногоор оршин сууж буй хүнийг хаягийн бүртгэлгүй оршин суугч гэнэ.</p>
Холбоос	-
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-ҮСХ, УБЕГ, МШХХТГ-ын даргын 2010 оны 4

	<p>дүгээр сарын 14-ний өдрийн 01/62, 226, 58 тоот хамтарсан тушаалын хавсралт</p> <p>-“Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, нэгтгэлийн маягтыг нөхөх заавар” Үндэсний Статистикийн Хороо</p>
<p>Байгууллага</p>	<p>Үндэсний статитикийн хороо</p>
<p>Нэмэлт тайлбар</p>	<p>Монгол улсын “Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль-д</p> <p>3 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж</p> <p>3.1.Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> <p>3.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулна.</p> <p>3.4.Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p> <p>Монгол Улсын “Иргэний хууль”-д:</p> <p>22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар</p> <p>22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.</p> <p>22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно.</p> <p>22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.</p>

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ДУГААР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Шаардлагатай үед үйлчлүүлэгчтэй холбоо барих утасны дугаар
Хэрэглээ	
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	#####
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	8
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	8
Хэмжих нэгж	
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчтэй холбоо барих утасны дугаар
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	




ЯАРАЛТАЙ ҮЕД ХОЛБОО БАРИХ ХҮНИЙ НЭР, ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ДУГААР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Яаралтай үед холбоо барих үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүн, хамаатан садан, ойр дотны хүний нэр, холбоо барих утасны дугаар
Хэрэглээ	-
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Чөлөөт текст
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	-
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	-
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Яаралтай үед холбоо барих үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүн, хамаатан садан, ойр дотны хүний нэр, холбоо барих утасны дугаар
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

III. АМБУЛАТОРИЙН ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ



АМБУЛАТОРИЙН КАБИНЕТИЙН НЭР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Амбулаторийн тусламж, үйлчилгээг үзүүлж буй кабинетийн нэр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	2
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	2
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Амбулаторын үзлэгийн кабинетийн код, нэр
Заавар	Эрүүл мэндийн яамнаас баталсан амбулаторын үзлэгийн кабинетийн төрөл, кодын жагсаалтыг ашиглана.
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	- Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягт бөглөх заавар
Байгууллага	Эрүүл мэндийн яам
Нэмэлт тайлбар	



ҮЗЛЭГИЙН ЭМЧИЙН НЭР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Амбулаторийн үзлэгийн кабинетын эмчийн нэр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	Чөлөөт төхт
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	Чөлөөт төхт
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Амбулаторын үзлэгийн кабинетын эмчийн нэр
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГИЙН ТОВЛОЛ АВСАН ОН САР ӨДӨР ЦАГ МИНУТ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн сонгосон үзлэгийн эмчид үзүүлэх хамгийн боломжит хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Огноо
Өгөгдлийн харагдах хэлбэр	ОО/СС/ӨӨ ЦЦ:ММ
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	10
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	10
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн сонгосон үзлэгийн эмчид үзүүлэх он, сар, өдөр, цаг, минут
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ОНОШИЛГООНИЙ КАБИНЕТААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ЦАГИЙН ТОВЛОЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн оношилгооны кабинетаар үйлчлүүлэх хамгийн боломжтой хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/, оношилгооны кабинет тус бүрээр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Огноо
Өгөгдлийн харагдах хэлбэр	ОО/СС/ӨӨ ЦЦ:ММ
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	10
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	10
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн оношилгооны кабинетаар үйлчлүүлэхээр товлосон он, сар, өдөр, цаг, минут
Заавар	Үйлчлүүлэгчийн оношилгооны кабинетаар үйлчлүүлэх хамгийн боломжтой хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/, оношилгооны кабинет тус бүрээр
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЦАГИЙН ТОВЛОЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн лабораторийн шинжилгээ өгөх хамгийн боломжтой хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/, шинжилгээний төрлөөр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Огноо
Өгөгдлийн харагдах хэлбэр	ОО/СС/ӨӨ ЦЦ:ММ
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	10
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	10
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн лабораторийн шинжилгээ өгөх хамгийн боломжтой хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/, шинжилгээний төрлөөр
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ТӨЛБӨР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Амбулаторийн үзлэгийн эмчийн үзлэгийн төлбөрийн тогтоосон хэмжээ
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөр тооцоо
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	###,###,###.## ₮
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	12
Хэмжих нэгж	₮
Өгөгдлийн утга	Эмчийн үзлэгийн төлбөрийн хэмжээ
Заавар	Эмчийн үзлэгийн төлбөрийн хэмжээг анх, давтан үзлэгийн хувьд ялгаатай байна.
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ОНОШИЛГООНИЙ ТӨЛБӨР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Оношилгооны кабинетуудын төлбөрийн тогтоосон хэмжээ, оношилгооны төрөл тус бүрээр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөр тооцоо
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	###,###,###.## ₮
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	12
Хэмжих нэгж	₮
Өгөгдлийн утга	Оношилгооны кабинетуудын төлбөрийн тогтоосон хэмжээ
Заавар	Оношилгооны кабинетуудын төлбөрийн тогтоосон хэмжээ оношилгооны төрөл бүрээр ялгаатай байна.
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Лабораторийн шинжилгээний төлбөрийн тогтоосон хэмжээ, шинжилгээний төрөл болон үзүүлэлт тус бүрээр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөр тооцоо
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоон
Өгөгдлийн харагдах хэлбэр	###,###,###.## ₮
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	12
Хэмжих нэгж	₮
Өгөгдлийн утга	Лабораторын шинжилгээний төлбөрийн тогтоосон хэмжээ
Заавар	Лабораторийн шинжилгээний төлбөрийн тогтоосон хэмжээ, шинжилгээний төрөл болон үзүүлэлт тус бүрээр Ялгаатай байна.
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ҮЗЛЭГ ЭХЭЛСЭН ОН САР ӨДӨР ЦАГ МИНУТ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгчийн эмчийн үзлэгийн цагийн товлолын дагуу амбулаторийн үзлэгийн эмчид үзүүлсэн он сар өдөр цаг минутаар илэрхийлэгдэнэ.
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Огноо
Өгөгдлийн харагдах хэлбэр	ОО/СС/ӨӨ ЦЦ:ММ
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	8
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	8
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Үйлчлүүлэгчийн эмчийн үзлэгийн цагийн товлолын дагуу амбулаторийн үзлэгийн эмчид үзүүлж, үзлэг эхэлсэн он сар өдөр цаг минут
Заавар	
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	-
Байгууллага	
Нэмэлт тайлбар	

ҮЗЛЭГИЙН ТӨРӨЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Үйлчлүүлэгч амбулаторийн эмчийн ямар төрлийн үзлэгт хамрагдсан хэлбэр
Хэрэглээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/төхт
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	1
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	1-Өвчний учир амбулаторид 2- Урьдчилан сэргийлэх 3- Идэвхтэй хяналт 4- Дуудлагаар гэрийн үзлэг 5- Гэрийн идэвхтэй хяналт
Заавар	<p>Үйлчлүүлэгч амбулаторийн эмчид үзүүлж, ямар төрлийн үзлэгт хамрагдснаас хамаарч зохих кодыг сонгоно.</p> <p>Өвчний учир амбулаторид – Өвчний онош тогтоолгож тусламж, үйлчилгээ авсан тохиолдлыг хэлэх бөгөөд ӨОУ 10 ангиллаас оношийн кодыг сонгоно.</p> <p>Урьдчилан сэргийлэх- Тус үзлэг нь ямар нэг шинж тэмдэггүй нууц явагдаж байгаа өвчнийг эрт илэрүүлж эмчилгээг эрт хийх зорилготой. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийтийн хамарсан үзлэг, ажилд ороход, жолооны эрх авахад, байгууллагын зардлаар хийгдэж байгаа үзлэг зэрэг орно.</p> <p>Идэвхтэй хяналт – Амбулаторийн үзлэгийн кабинетийн эмчийн хяналтанд байдаг үйлчлүүлэгч хяналтын хугацаанд тодорхой давтамжтайгаар үзүүлэх үзлэг</p> <p>Гэрийн идэвхтэй хяналт- Өрхийн эмч нь Эрүүл мэндийн сайдын 1993 оны А/180 тоот тушаалын дагуу 15 хүртэлх насны эрүүл хүүхдийг үлгэрчилсэн загвараар хянаж, гэрийн идэвхтэй хяналтыг хийнэ.</p>
Холбоос	
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	- Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягт бөглөх заавар

Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг

42



Байгууллага	Эрүүл Мэндийн Яам
Нэмэлт тайлбар	

ӨВЧНИЙ ТӨРӨЛ	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Өвчний учир анх удаа амбулаторийн тусламж үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн хувьд тухайн өвчлөлийг бүртгэх бөгөөд тухайн өвчлөл шинэ эсвэл хуучин эсэхийг тогтооно.
Хэрэглээ	Хүн амын өвчлөл, нас баралтын статистик
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Тоо
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/текст
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	1
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	1
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	1- Шинэ 2- Хуучин
Заавар	Өвчний учир анх удаа амбулаторийн тусламж үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн хувьд тухайн өвчлөлийг бүртгэх бөгөөд тухайн өвчлөл шинэ эсвэл хуучин эсэхийг тогтооно. Хэрэв тухайн үйлчлүүлэгчийн амьдралдаа анх удаа тухайн өвчнөөр эмчид хандаж байгаа бол шинэ өвчлөл, харин өмнө тухайн өвчнөөр өөр эмнэлэгт хандаж эмчилгээ, оношилгоо хийлгэж байсан бол хуучин өвчин гэж бүртгэнэ.
Холбоос	Өртөг ойролцоо оношийн бүлэг
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	- Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягт бөглөх заавар
Байгууллага	Эрүүл мэндийн Яам
Нэмэлт тайлбар	

Үндсэн онош	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Өвчтнийг эмчилгээ, оношилгоо хийлгэхэд хүргэсэн үндсэн онош бөгөөд хэрэв ийм өвчин, эмгэг нэгээс олон илэрсэн бол хамгийн их зардал гаргасныг нь үндсэн өвчнөөр сонгож авна. (Өвчний олон улсын ангилал, гарын авлага, 2-р боть, ДЭМБ)
Хэрэглээ	Хүн амын өвчлөл, нас баралтын статистик
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Техт /Код
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	Чөлөөт текст/5
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	Чөлөөт текст/5
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Өвчний олон улсын 10 дугаар ангиллын 4 тэмдэглэгээт код
Заавар	Эмчлэгч эмчийн үндсэн онош гэж оношилж, тусламж үйлчилгээ үзүүлсэн оношийг өвчний олон улсын 10 дугаар ангилалын 4 тэмдэглэгээт кодоор кодолно. Үндсэн онош 1-ээс илүүгүй байна. Өвчтнийг эмчилгээ, оношилгоо хийлгэхэд хүргэсэн үндсэн онош бөгөөд хэрэв ийм өвчин, эмгэг нэгээс олон илэрсэн бол хамгийн их зардал гаргасныг нь үндсэн өвчнөөр сонгож авна.
Холбоос	Өртөг ойролцоо оношийн бүлэг
Мэдээллийн эх сурвалж	
Үндсэн баримт	Өвчний олон улсын 10 дугаар ангилал
Байгууллага	Эрүүл мэндийн яам, ДЭМБ
Нэмэлт тайлбар	

ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН	
Эрүүл мэндийн өгөгдлийн тодорхойлолт	
Метадата	Шивж оруулах өгөгдөл
Тодорхойлолт	Өвчний олон улсын 10 дугаар ангилалын 19 бүлэгт ангилсан өвчин, эмгэгийн гадны шалтгааныг тодотгох зорилгоор нэмэлтээр хэрэглэдэг код.
Хэрэглээ	Хүн амын өвчлөл, нас баралтын статистик
Эрүүл мэндийн өгөгдлийн бүтэц	
Өгөгдлийн төрөл	Үсгэн
Өгөгдлийн харагдах хэлбэр	Код/текст
Өгөгдлийн хамгийн бага хэмжээс	5
Өгөгдлийн хамгийн их хэмжээс	5
Хэмжих нэгж	-
Өгөгдлийн утга	Өвчний олон улсын 10 дугаар ангиллын 20 бүлгийн 4-т тэмдэглэгээт код
